

Чех хэлнээс орчуулав.

No. C.j 305606/2011-KKM

Бүгд найрамдах Чех улсын Гадаад хэргийн яам Прага дахь Монгол улсын Элчин сайдын яаманд хүндэтгэл илэрхийлэн Дипломат, албан паспорт эзэмшигчид харилцан визгүй зорчих тухай Чех, Словакийн холбооны улсын болон Монгол улсын засгийн газар хоорондын хэлэлцээрийн /1992 оны 6 дугаар сарын 26, Улаанбаатар/ 4 дүгээр заалтыг үндэслэн Чехийн тал визгүй зорчих харилцааг Монголын хүчин төгөлдөр Дипломат паспорт эзэмшигчдээр хязгаарлаж түүнийг 2011 оны 9 дүгээр сарын 1-нээс эхлэн хэрэгжүүлэхээ мэдээлж байна.

Монголын албан паспорт эзэмшигчид 2011 оны 9 дүгээр сарын 1-нээс эхлэн Чехийн газар нутагт нэвтрэх, байх тохиолдолд виз авах шаардлагатай болж байна.

Монгол улс зорчих баримт бичгүүдийг хуульчлаагүй ба Монголын байгууллагууд албан паспортыг өргөн хүрээг хамарсан иргэдэд олгодог бөгөөд тэдгээр паспорт нь биометрийн ялтасан хамгаалалтгүй байгаа нөхцөл байдал нь Чехийн талыг энэхүү алхам хийхэд хүргэсэн болно.

Чехийн Гадаад хэргийн яам энэ завшааныг ашиглан Прага дахь Монголын Элчин сайдын яаманд өөрийн гүн хүндэтгэлээ дахин илэрхийлж байна.

2011 оны 7 дугаар сарын 29-ний
өдөр, Прага хот

Монгол улсын Элчин сайдын яаманд
Прага хот

Чехийн Гадаад хэргийн яам
АТ/ЗТ - хэргийн
АТ/ЗТ - хэргийн
АТ/ЗТ - хэргийн

